

ШИНЭ НОМ



ЦЭНД ГҮН ба МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ АНХНЫ МОНГОЛ ОРЧУУЛГА




Улаанбаатар

Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын Засгийн газарт Гадаад хэргийг Бүгд эрхлэн шийтгэх Яамны Дэд сайдаар ажиллаж байсан Бодлогот гүн Цэнд 1917 онд Монголын нууц товчоог монгол бичгээр сийрүүлсэн ба мөн монгол хэлээр бүрэн орчуулжээ. Түүний энэхүү бүтээлийн хуулбар болон сийрүүлэг, орчуулга хоёрыг нь салган бичсэн хувилбар Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, Буриад дахь Оросын ШУА-ийн Монгол, төвд, буддын судлалын хүрээлэн, мөн Монгол улсын Үндэсний номын санд тус тус хадгалагдаж буй билээ. Эдгээрээс Монгол

Цэнд гүн ба Монголын нууц товчооны анхны монгол орчуулга. Удиртгал бичиж хэвлэлд бэлдсэн Б.Түвшинтөгс. Уб., 2020. 400 х. ISBN 978-9919-9551-7-5

улсын Үндэсний номын санд хадгалагдаж буй нэгэн хувилбарыг Монголын нууц товчооны 780 жилийн ойд зориулан уншигч олноо толилуулан энэхүү бүтээлийг туурвисан байна. Тус бүтээлд дээр дурдсан орчуулга, сийрүүлгүүдийн хувь заяа, учир холбогдол, үнэ цэнийн талаар тодорхой дурдсанаас гадна Монголын нууц товчооны хятад утгачилсан орчуулгыг Цэнд гүн хэрхэн монгол хэлээр буулгасныг харуулах үүднээс эхийн гэрэл зураг, түүний кирилл хөрвүүлгийг оруулсан юм. Мөн удиртгал хэсэгт Цэнд гүн Монголын нууц товчоог орчуулах болсон түүх, дээр дурдсан бүрэн ба салгаж хуулсан эхүүдийн тухай, хэвлэгдсэн байдал зэргийг дэлгэрэнгүй оруулж мөн холбогдох баримт, зураг сэлтээр баримтжуулсан байна. Тухайлбал, Цэнд гүнгийн хийсэн орчуулгын 4-р бүлгийг 1936 онд багш Далхжав 3 ба 4-р ангийн сурагчдад зориулсан унших бичигт хэвлэн нийтэлсэн нь Монголын нууц товчоог манай улсад хэвлэсэн одоогоор мэдэгдэж буй анхны тохиолдол юм. Тиймээс энэ хэвлэлийн зургийг олон нийтэд танилцуулах зорилгоор хэвлэжээ. Түүнчлэн Цэнд гүнгийн уг орчуулгыг кирилл бичгээр хөрвүүлэхдээ зохих тайлбар, сэлтийг тухай бүр оруулсан байна.



Монголчууд бид түүхэндээ арваад нэрийн бичиг хэрэглэж ирсэн бөгөөд тэдгээр дотроос монгол бичгийг хамгийн урт хугацаагаар хэрэглэж байна. Монгол бичгийг чухам хэн, хэдийд зохиосон талаар тодорхой баримт үгүй ч судлаачид дараах хэдэн таамаглалыг дэвшүүлдэг. Үүнд: 1. Согд бичгийг уйгурууд Х зууны үед, монголчууд уйгураас XIII зуунд авсан, 2. Монголчууд уйгур улсыг хүчирхэгжин мандаж байх үед нь буюу Х зууны үед тэдний бичгийг авсан, 3. Монгол, уйгур хоёр үндэстэн Согдоос нэг үед бичиг авсан зэрэг саналыг дурдаж болох боловч аль нь ч бүрэн дүүрэн баталгаа нотолгоогүй юм. Хэдий тийм ч монголчууд бид уг бичгийг өдгөө хүртэл тууштай хэрэглэсээр байна. Энэ бүхий л хугацаанд монгол бичгээр хад, чулуу, мод, шавар, төмөр, үйс, цаас зэрэг материал дээр гараар болон бар хэвлэлээр бичиж, зурж, хэвлэж, сийлж тэмдэглэсэн олон мянган дурсгал хадгалагдаж иржээ. Монгол бичгийн өнөө мэдэгдэж байгаа эдгээр дурсгалаас хамгийн эртнийх нь Чингисийн чулууны бичиг буюу шинжлэх ухаанд Хархираагийн чулууны

Чингисийн чулууны бичгийн судалгаа. 200 жилийн түүх: судлаач, бүтээл, тайлбар. Судалгааны тойм бичин, номзүй үйлдэж, бүтээлүүдийг эмхэтгэсэн Б.Түвшинтөгс. Уб., 2021, 448 х. ISBN 978-9919-9581-8-2

бичиг, Есүнгэгийн чулууны бичиг гэх зэрэг нэрээр алдаршсан бичээс бөгөөд уг дурсгалыг нээж олоод 200 илүү жил (1818 онд шинжлэх ухаанд мэдээлсэн) болж байна.

5 мөр, 21 үгтэй энэ дурсгалын бичээс монгол хэлний түүхэн үгийн сангийн чухал дурсгал болохын зэрэгцээ XIII зууны үеийн монголчуудын бичгийн соёлыг тодорхой харуулдаг гэрч юм. Учир нь энэ бичээст Чингис хаан, Хамаг Монгол улс, Есүнгэ, Бух сочирай зэрэг оноосон нэрийг тэмдэглэсэн нь түүхэн нэрзүйн хувьд сонирхолтой, мөн Чингис хаан, Есүнгэ нарын нэрийг мөр тэтгэж бичсэнээс харвал бичгийн тогтсон дэг байсны баталгаа болно.

Энэ хугацаанд уг дурсгалыг судалсан, танилцуулсан, тайлбарласан зэрэг олон тооны бүтээл (дахин хэвлэлийг тооцохгүйгээр бид 82 бүтээл бүртгэсэн) хэвлэгджээ. Тиймээс нэг дурсгалд зориулсан энэ олон бүтээлийг нэгтгэн үзэх нь судалгааны аргагүй, шинжлэх ухааны түүх бичлэг, монгол судлалын түүх зэрэг салбарт олон талын ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Энэхүү бүтээл хоёр хэсгээс бүрдэнэ. Нэгд, уг дурсгалыг нээж олсноос өнөөг хүрч ирсэн хугацаан дахь судалгааны бүтээлүүдийг нэгтгэн дүгнэсэн тойм, холбогдох бүтээлүүдийн жагсаалт, хоёрдугаар хэсэгт, энэхүү дурсгалыг тайлж уншихад зориулсан судалгааны бүтээлүүдээс дээжлэн авсан 21 өгүүллийг эмхэтгэн оруулжээ. Түүнчлэн 1920-оод оны үед Судар бичгийн хүрээлэнгээс хэвлүүлсэн Чингисийн чулууны бичгийн дардсыг мөн 1962 онд гарсан Чингис хаан сэдэвт 4 номиналь маркиг тус бүр эх хувиар нь хавсаргасан онцлогтой.




МОНГОЛ ХЭЛ СУДЛАЛЫН ТҮҮХ 3 боть

Монголчууд бид бичиг үсгийн соёлт үндэстний хувьд өөрийн хэлний зүй тогтлыг нийгэм түүхийн нөхцөл байдлаас шалтгаалан дундад зууны үеэс эхлэн энэтхэг-төвөдийн хэл шинжлэлийн үүднээс, XIX зууны үеэс энэтхэг-европын хэл шинжлэлийн онолын хүрээнд судалсаар иржээ. Монгол хэлийг судалж эхэлснээс эдүгээх хүртэлх хугацаанд монгол хэлний түүх, гарал, хэл аялгуу, хэл зүй, үгийн сан болоод бусад салбар судлалуудад арга зүйн болоод онолын сэтгэлгээний өөрчлөлт гарч, ерөнхий хэл шинжлэл болон салбар хэл шинжлэлийн ухаанууд хөгжиж, түүний хэрээр монгол хэл судлалын судалгааны түүх өргөжсөөр байна. Бид монгол хэлний хөгжлийн түүхэн үеүдийн хувьсал болоод онцлог шинжийг тусгасан үсэг бичгүүдийг зохион хэрэглэж байсны хувьд үсэг бичгийн судалгаа болон тэдгээр үсэг бичгээр уламжлан ирсэн дурсгалын судлал ч мөн судалгааны зохих түвшинд хүрсэн энэ үед Монгол улсын хэл шинжлэлийн салбарын эрдэмтэд “Монгол хэлний бүрэн хэл зүй” хэмээх судалгааны хамтарсан бүтээлийг туурвихаар зорьж буй бөгөөд тус бүтээлийн удиртгал болгож МУИС, МУБИС, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн судлаачдын туурвисан “Монгол хэл судлалын түүх” III боть бүтээлийг толилуулж байна. Тус бүтээл нь монгол хэлийг судлагч хэл бичгийн мэргэжилтнүүд хийгээд эх хэлнийхээ түүхийг сонирхон судлагч хэн бүхэнд чухал хэрэгцээтэй бүтээл юм.

Тус III боть бүтээлийн эхний боть “Монгол хэл, аялгуу, үсэг бичиг, авиа судлал” нь Өмнөх үг (х.7-8), Нэгдүгээр бүлэг “Монгол хэлний түүх, аялгуу судлал” (х.9-79), Хоёрдугаар бүлэг “Монголчуудын үсэг бичиг, бичгийн дурсгалын судлал” (х.80-185), Гуравдугаар бүлэг “Монгол хэлний авиа судлал” (х.186-247), Ном зүй (х.248-311), Хавсралт (х.312-314), Нэрийн хэлхээ (х.315-318) гэсэн бүтэцтэй бөгөөд дэд боть болох “Монгол хэлний үг зүй, өгүүлбэр судлал” боть нь Өмнөх үг (х.7-8), Нэгдүгээр бүлэг “Бүтээвэр судлал” (х.9-28), Хоёрдугаар бүлэг “Үгийн аймаг судлал” (х.29-80), Гуравдугаар бүлэг “Хэл зүйн айн судлал” (х.81-139), Дөрөвдүгээр бүлэг “Үг бүтэх ёс” (х.140-156), Тавдугаар бүлэг “Өгүүлбэр судлал” (х.157-308), Ном зүй (х.309-334), Хавсралт (х.335-337), Нэрийн хэлхээ (х.338-344) гэсэн бүтэцтэй юм. “Монгол хэлний үгийн сан, найруулга судлал” (хэмээх) III боть нь Өмнөх үг (х.7-8), Нэгдүгээр бүлэг “Монгол хэлний үгийн сангийн бүрэлдэхүүн судлал” (х.9-44), Хоёрдугаар бүлэг “Монгол хэлний үгийн сангийн бүрэлдэхүүн судлал” (х.45-192), Гуравдугаар бүлэг “Монгол хэлний үгийн сангийн хэрэглээ судлал” (х.193-235), Дөрөвдүгээр бүлэг “Монгол хэлний найруулга судлал” (х.236-287), Ном зүй (х.288-329), Хавсралт (х.330-332), Нэрийн хэлхээ (х.333-344) гэсэн бүтэцтэй бөгөөд дээрх дэд сэдвүүдийн дагуу гадаад дотоодын судлаачдын нийтлүүлсэн судалгааны өгүүлэл, ном товхимол, нэг сэдэвт зохиол зэрэг хэрэглэгдэхүүнийг ашиглан шинэ жишээ баримт, дүгнэлт шийдлийг он цагийн дарааллаар түүхчлэн өгүүлсэн байна.

**Ч.Баттулга. МОНГОЛ ОРОН СУДЛАЛ.
Уб., 2020, 214 х.**



Монголыг сонирхон судлагч гадаад, дотоодын мэргэжилтэн олширч, судлаачдын судалгааны зорилго, хэрэгцээ шаардлагаас хамааран монгол судлалын цар хүрээ өргөжин хэл, соёл, шашин, түүхийн асуудлаар хязгаарлалгүй улс төр, эдийн засаг, бүс нутаг, орон судлал гээд монголтой холбогдох олон салбар судлал хөгжиж байна. Монгол судлалыг анх сонирхон судлагч болоод монголд амьдардаг гадаадын иргэдэд тус орны түүх, соёл, урлаг, шашин шүтлэг, зан заншил, нийгмийн байгуулал, аж ахуй, байгаль цаг уурын онцлогийн талаар олж мэдэх шаардлага тулгардаг билээ. Иймд Монгол орны талаарх дээрх мэдээллийг багтаасан тус ном нь Монголыг сонирхон судлагч хэн бүхэнд хэрэгцээт бүтээл болох юм.

* * *

2020-2024 оны хооронд хэрэгжих “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг Монгол улсын Засгийн газраас батлан хэрэгжүүлэх тогтоол гаргасантай холбогдон монгол хэл, бичгийн судлаач болон хэл, бичгийн сургалт эрхлэн явуулдаг байгууллагууд анхлан суралцагчдад зориулсан ном товхимол, сургалтад ашиглах хэрэглэгдэхүүн боловсруулах зэргээр сурч, судлах хэн бүхний хэрэгцээг тодорхойлон тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулах шаардлага тулгарч байгаа юм. Үүнтэй холбоотойгоор гадаадын судлаачдад ч мөн монгол бичгийг сурах, хэрэглэх хэрэгцээ үүсэж байгаа бөгөөд монгол бичгийг сонирхон судлагч ч цөөнгүй билээ. Англи хэлээр уншиж, судалдаг хэн бүхэнд зориулсан тус ном нь монгол бичгийн үндсэн зурлагаас эхлээд үг, үе холбон бичиж сурах хүртэлх үе шатуудыг логик дэс дараатайгаар тайлбарлаж, сурснаа бататгах дасгал ажлыг боловсруулж, бие даан сурахад зориулсан бүтээл юм.

* * *

**Б.Баяртуул & Ines Stolpe
MONGOLIAN SCRIPT WORKBOOK**

